

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН  
2009 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААРХ  
НЭГТГЭЛИЙН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА**

2009.06.03

Улаанбаатар хот

**НЭГ. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

ДД	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлант улирлаар	Өмнөх оны мөн үеэр
1	ББСБ-ын тоо	132	131
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	442	436
3	Ажиллагсадын тоо	603	633
4	Салбар нэгжийн тоо	46	46
5	Харилцагчдын тоо /мянган төгрөгөөр/	40.2	32.6
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	79,142,638.6	70,588,345.6
	<i>Банкны салбарт эзлэх хувь /</i>	2.0%	2.0%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	46,029,757.4	36,138,324.4
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	1.7%	1.7%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	59,294,746.6	48,417,730.6
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	17.2	12.5%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	50,953,035.0	43,082,678.8
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	20.3	-
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	3,404,143.1	2,369,641.4
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	8,356,435.2	4,151,783.9
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	6,826,386.0	3,448,007.0
1	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,530,049.2	703,776.8
14	Активын өгөөж /ROA/	8.7	4.7
15	Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	11.8	2.3
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	11	11
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	8.3	8.4
2	Нийт актив /мянган төгрөгөөр/	15,471,456.73	15,841,531.78
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	19.5	22.4
3	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	9,394,216.65	4,178,485.76
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	20.4	11.6
4	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	9,982,584.90	12,003,040.41
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	16.8	24.8
5	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	10,577,790.25	12,166,660.44
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	20.8	28.2
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	23	21
	<i>ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь</i>	17.4	16.0
2	Нийт актив /мянган төгрөгөөр/	2,016,875.55	2,009,307.67
	<i>ББСБ-ын нийт активт эзлэх хувь</i>	2.5	2.8
3	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	1,641,054.79	1,481,993.34
	<i>ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	3.6	4.1
4	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	1,696,113.79	1,330,227.55
	<i>ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь</i>	2.9	2.7
5	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	1,459,320.94	1,131,699.07
	<i>ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь</i>	2.9	2.6

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйлчилгээ, үйл ажиллагаануудыг ББСБ-уудын эрхэлж буй төрлөөр нь ангилж үзэхэд дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны төрөл	Тоо
Зээл	130
Факторингийн үйлчилгээ	7
Санхүүгийн түрээс	5
Төлбөрийн баталгаа гаргах	3
Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ	7
Гадаад валютын арилжаа	51
Итгэлцлийн үйлчилгээ	13
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	3
Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	8

## ХОЁР. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Тайлант улиралд нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар, хүүгийн орлого авчирдаг актив 36,138.3-46,029.8 сая төгрөг болж өссөнтэй холбоотойгоор нийт орлого өмнөх оны мөн үеэс *1омнох оны мөн үеэд нийт орлого 4,151.8 сая төгрөг* 2.0 дахин өссөн ба дараах бүтэктэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ДҮН	ХУВЬ
1	<b>ХҮҮГИЙН ОРЛОГО</b>	<b>3,507,697.5</b>	<b>42.0</b>
	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	3,422,051.2	41.0
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	73,919.2	0.9
	Бусад хүүгийн орлого	11,727.2	0.1
2	<b>ХҮҮГИЙН БУС ОРЛОГО</b>	<b>4,738,684.3</b>	<b>56.7</b>
	Гадаад валютын арилжааны орлого	1,691,037.4	20.2
	Үнэт цаасны арилжааны орлого	233.9	0.0
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	2,800,682.3	33.5
	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	6,066.5	0.1
	Санхүүгийн үйлчилгээний орлого	240,664.2	2.9
	Санхүүгийн түрээсийн орлого	377.2	0.0
	Итгэлцлийн үйлчилгээний орлого	147.3	0.0
	Мөнгөн гүйвуулгын орлого	50,431.5	0.6
	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	20,874.7	0.2
	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	93,744.1	1.1
	Бусад	75,089.4	0.9
3	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>109,794.6</b>	<b>1,3</b>
4	<b>Ердийн бус орлого</b>	<b>258.8</b>	<b>0.0</b>
	<b>НИЙТ</b>	<b>8,356,435.20</b>	<b>100.0</b>

Нийт орлогын 53.8 хувийг гадаад валют, үнэт цаасны арилжааны болон ханшийн тэгшитгэлийн орлого, харин зээлийн хүүгийн орлогийн дүн өмнөх оны мөн үеэс өссөн ч нийт орлогын өсөлтийн хурдацаас бага байгаагаас 42.0 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна. Энэ нь

Нийт зардал өмнөх оны мөн үеэс */өмнөх оны мөн үед нийт зардал 3,448.0 сая төгрөг/* зардал зүйл тус бүрээр өссөнөөр, нийт зардал 2.0 дахин өссөн ба дараах бүтэцтэй байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ДҮН		ХУВЬ
<b>1</b>	<b>ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>	<b>377,525.4</b>		<b>5.5</b>
	Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	161,784.1		2.4
	Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	133,381.4		2.0
	Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал	82,359.9		1.2
<b>2</b>	<b>ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ</b>	<b>5,030,833.1</b>		<b>73.7</b>
	Гадаад валютын арилжааны зардал	1,463,250.0		21.4
	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	1,510,011.3		22.1
	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн зардал	18,892.6		0.3
	Боловсон хүчний холбогдолтой зардал	915,765.8		13.4
	Бусад зардал	1,122,913.4		16.4
<b>3</b>	<b>БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,200,783.0</b>		<b>17.6</b>
<b>4</b>	<b>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>35,577.7</b>		<b>0.5</b>
<b>5</b>	<b>Ердийн бус зардал</b>	<b>5,658.0</b>		<b>0.1</b>
<b>6</b>	<b>ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ</b>	<b>176,008.7</b>		<b>2.6</b>
	<b>НИЙТ</b>	<b>6,826,385.90</b>		<b>100.0</b>

Тухайлбал, гадаад валют, үнэт цаасны арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал өсч, нийт зардлын 28.3-43.5 хувийг, зээлийн чанар муудсантай холбоотойгоор эрсдлийн зардлууд өсч, нийт зардлын 7.3-17.6 хувийг тус тус эзлэх болсон байна.

Харин банк, санхүүгийн байгууллага, төслийн нэгжээс авсан зээлийн хүүгийн зардлын нийт зээлд элэх хувийн жин 9.7-5.5 хувь болж буурчээ. Энэ нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болох зээлийн хүүгийн зардал тогтвортой байгаатай холбоотой юм.

ББСБ-ууд нийт 1,530.0 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад */өмнөх оны мөн үеийн цэвэр ашиг 703.8 сая төгрөг/* 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь нийт орлогын өсөлтийн хурдац нийт зардлын өсөлтийн хурдацаас харьцангуй өндөр байгаатай холбоотой байна.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 105 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 79.5 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 10.7 мянган төгрөгөөс 234.0 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Харин 26 ББСБ буюу нийт ББСБ-уудын 19.7 хувь нь 18.0 мянган төгрөгөөс 359.9 сая төгрөг хүртэл алдагдалтай ажилласан байна.

Түүнчлэн ББСБ-ууд нийт 4,700.1 сая төгрөгийн ашгийг хуримтлуулан тооцсон байна.

## ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 3.1 Активын өөрчлөлтийн талаар

ББСБ-уудын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ		Тайлант үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>75,249,362.2</b>	<b>95.1</b>	<b>66,225,097.8</b>	<b>93.8</b>	<b>9,024,264.40</b>	<b>1.3</b>
1	Мөнгөн хөрөнгө	25,066,777.9	31.7	19,462,358.5	27.6	5,604,419.40	4.1
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	29,944.1	0.0	4,286,696.9	6.1	-4,256,752.80	-6.1
3	Зээл /цэврээр/	43,142,810.7	54.5	34,855,902.5	49.4	8,286,908.20	5.1
	(Зээлийн эрсдлийн сан)	2,886,946.6	3.6	1,282,422.0	1.8	1,604,524.60	1.8
4	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	86,015.9	0.1	221,487.2	0.3	-135,471.30	-0.2
	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	86,347.5	0.1	193,688.2	0.3	-107,340.70	-0.2
	(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдлийн сан)	17,231.7	0.0	93,498.1	0.1	-76,266.40	-0.1
	Өмчлөх бусад хөрөнгө	16,900.1	0.0	121,297.1	0.2	-104,397.00	-0.2
5	Бусад хөрөнгө	6,923,813.6	8.7	7,394,258.7	10.5	-470,445.10	-1.8
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,673,926.8	2.1	867,868.6	1.2	806,058.20	0.9
6	Нийт авлага	2,478,662.6	3.1	3,170,221.1	4.5	-691,558.50	-1.4
	(Авлагын эрсдлийн сан)	9,787.2	0.0	3,551.2	0.0	6,236.00	0
7	Бусад актив	2,781,011.4	3.5	3,359,720.3	4.8	-578,708.90	-1.3
B	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>3,893,276.4</b>	<b>4.9</b>	<b>4,363,247.9</b>	<b>6.2</b>	<b>-469,971.50</b>	<b>-1.3</b>
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	3,893,276.4	4.9	4,363,247.9	6.2	-469,971.50	-1.3
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,100,880.6	1.4	938,175.7	1.3	162,704.90	0.1
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>79,142,638.6</b>	<b>100.0</b>	<b>70,588,345.6</b>	<b>100.0</b>	<b>8,554,293.00</b>	

Тайлант хугацаанд нийт эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт актив өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар өсч, нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна.

Тухайлбал, нийт эх үүсвэр нэмэгдэж зээлийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотойгоор хүүгийн орлого авчирдаг активуудын нийт активт эзлэх хувийн жин 49.4-54.5 хувь, зээлийн багцын чанар муудсантай холбоотойгоор зээлийн эрсдлийн сангийн нийт активт эзлэх хувийн жин 1.8-3.6 хувь тус тус өсчээ.

Харин богино хугацаат хөрөнгө оруулалтын нийт активт эзлэх хувь хэмжээ 6.1-0.01 хувь, өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн цэвэршүүлсэн дүн 0.3-0.1 хувь болж тус тус буурчээ.

### 3.2 Зээлийн багцын чанар

ББСБ-уудын нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл нийт эх үүсвэр 12.1 хувиар нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнөх оны мөн үеэс 27.4 хувиар өсч нийт активын 58.2 хувийг **өмнөх оны мөн үед нийт активын 51.2 хувь** эзэлж байна. Зээлийн ангилалыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

	Ангилал	2009.03.31		2008.03.31		өөрчлөлт
		Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн	Хувь	

ББСБ-ын 2009 оны нэгдүгээр улирлын изгтгэлийн танишигуулга

1	<b>Хэвийн зээл</b>	<b>39,171,680.95</b>	85.1	<b>33,837,894.3</b>	93.6	5,333,786.64
2	<b>Хугацаа хэтэрсэн зээл</b>	<b>2,120,125.47</b>	4.6	<b>730,475.14</b>	2.0	1,389,650.33
3	<b>Чанаргүй зээл. Үүнээс:</b>	<b>4,737,950.95</b>	10.3	<b>1,569,954.98</b>	4.3	3,167,995.97
	<i>a/Хэвийн бус</i>	1,876,040.15	4.1	372,399.30	1.0	1,503,640.85
	<i>б/Эргэлзээтэй</i>	1,010,810.47	2.2	225,334.29	0.6	785,476.18
	<i>в/Muu</i>	1,851,100.32	4.0	972,221.39	2.7	878,878.93
	<b>НИЙТ</b>	<b>46,029,757.37</b>	<b>100.0</b>	<b>36,138,324.4</b>	<b>100.0</b>	<b>9,891,432.94</b>

Санхүүгийн хямралаас шалтгаалж, зээлийн эргэн төлөгдөх нөхцөлд өөрчлөлт орсондой холбоотойгоор зээлийн багцын чанар муудсан байна. Тухайлбал, хэвийн зээлийн өрийн үлдэгдэл өссөн ч, нийт зээлийн өрийн үлдэгдэл эзлэх хувийн жин 93.6-85.1 хувь болж буурсан бол хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өссөнөөр нийт зээлийн багцад эзлэх хувийн жин мөн өссөн байна.

## ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТАЛААР

### 4.1 Нийт эх үүсвэрийн өөрчлөлтийн талаар

ББСБ-уудын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үтэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		Тайлант үе		Өмнөх оны мөн үе		Өөрчлөлт		
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	
A	<b>Өр төлбөр</b>	<b>17,316,274.</b>	<b>5</b>	<b>21.9</b>	<b>15,014,206.</b>	<b>0</b>	<b>2,302,068.50</b>	<b>0.6</b>
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	3,404,143.1	4.3	2,369,641.4	3.4	1,034,501.70	0.9	
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	8,763,502.0	11.1	7,844,190.5	11.1	919,311.50	0	
3	Бусад эх үүсвэр	2,563,686.1	3.2	2,088,026.2	3.0	475,659.90	0.2	
5	Төслийн зээлийн санхүүжилт	2,584,943.4	3.3	2,712,348.0	3.8	-127,404.60	-0.5	
	<b>Бусад өр төлбөр</b>	<b>2,531,617.5</b>	<b>3.2</b>	<b>7,156,409.0</b>	<b>10.1</b>	<b>-4,624,791.50</b>	<b>-6.9</b>	
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	258,507.1	0.3	221,112.4	0.3	37,394.70	0	
7	Бусад пассив	2,273,110.4	2.9	6,935,296.5	9.8	-4,662,186.10	-6.9	
	<b>Нийт өр төлбөр</b>	<b>19,847,892.</b>	<b>0</b>	<b>22,170,615.</b>	<b>0</b>	<b>-2,322,723.00</b>	<b>-6.3</b>	
B	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>59,294,746.</b>	<b>6</b>	<b>74.9</b>	<b>48,417,730.</b>	<b>6</b>	<b>10,877,016.00</b>	<b>6.3</b>
	Ердийн хувьцаа	50,908,090.	5	64.3	42,837,828.	8	8,070,261.70	3.6
	Давуу эрхтэй хувьцаа	44,944.4	0.1	244,850.0	0.3	-199,905.60	-0.2	
	Тухайн үеийн ашиг/алдагдал	1,530,049.2	1.9	703,776.8	1.0	826,272.40	0.9	
	Хуримтлагдсан ашиг/алдагдал	4,700,054.1	5.9	2,160,617.1	3.1	2,539,437.00	2.8	
	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	398,133.9	0.5	737,460.1	1.0	-339,326.20	-0.5	
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>79,142,638.</b>	<b>6</b>	<b>100.0</b>	<b>70,588,345.</b>	<b>6</b>	<b>8,554,293.00</b>	<b>0</b>

Тайлант хугацаанд ББСБ-уудын өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмч 22.5 хувиар, итгэлцлийн үйлчилгээний өглөг 43.6 хувиар, банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн өглөг 11.7 хувиар тус тус өссөнтэй холбоотойгоор нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс **12.1** хувиар өсчээ.

Нийт эх үүсвэрийн бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал, өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац нь нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас их байгаагаас өөрийн хөрөнгийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 60.7-64.3 хувь болж өссөн, бусад пассив буюу бусдад өгөх өглөг 3.0 дахин буурч, нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 9.8-2.9 хувь, төслийн зээлийн санхүүжилтийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 4.9 хувь болж тус тус буурчээ.

Нийт эх үүсвэрийн 74.9 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлж байгаа нь нэг талаас Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу ББСБ нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхэлнэ гэсэнтэй нийцэж байгаа, нөгөө талаас бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж байна.

## ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

ББСБ-ын нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

**54,762,820.53**

- нийт өөрийн хөрөнгө **59,294.7** сая төгрөг, эрсдлээр жигнэсэн актив **54,762.8** сая төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд **106.87** хувь, өөрийн хөрөнгийн хувьд **109.69** хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд **73.95** хувь,

- түргэн борлогдох актив **25,275.7** сая төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө /цэвэршүүлж жигнэсэн/ **13,711.2** сая төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа **184.34** хувь,

- Гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, касст байгаа бэлэн валют, банкин дахь валютын харилцах дансан дахь үлдэгдэл нийт **16,896.4** сая төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө **7,350.7** сая төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдлийн зохисой харьцаа нь **16.1** хувь,

- Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл **3,404.1** сая төгрөг, хувьцаат капитал **50,953.0** сая төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа **6.68** хувь,

- Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө **1,697.6** сая төгрөг, нийт актив **79,142.6** сяа төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа **2.14** хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангасан байна.

Харин эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 125/50 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан өөрчлөлтийн дагуу 2,959.4 сая төгрөгийн эрсдлийн сан байгуулахаас 2,915.1 сая төгрөгөөр буюу 44.3 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна.

## ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Хэдийгээр ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр санхүү, төлбөрийн чадварын гол гол үзүүлэлтүүд зерэг буюу Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа ч дийлэнх ББСБ-ын өрсөлдөх чадвар сул хэвээр байна. Үүнийг зарим үзүүлэлтүүдээр илэрхийлбэл, дараах байдалтай байна.

Нийт активаар нь ангилахад томоохон буюу 1,000.0 сая төгрөгөөс дээш активтай 17 ББСБ-ын активын нийлбэр 44,370.0 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-ын нийт активын 56.1 хувийг, тэдгээрийн олгосон зээлийн өрийн үлдэгдэл 25,591.1 сая төгрөг байгаа нь нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 55.6 хувийг эзэлж байгаагаас харж болохоор байна.

Энэ нь санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, хүрэлцээ бага байгаатай холбоотой байна.

ББСБ-уудын активын чанар Монгол оронд нүүрлэсэн санхүүгийн хямралтай холбоотойгоор салбарын хэмжээгээр муудах хандлагад орж, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өссөнөөр нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 14.9 хувь нь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд ангилагдаж, нийт активын 8.7 хувийг эзлэх болсон байна.

**Түүнчлэн хүүгийн орлого авчирдаг актив нийт активын 58.2 хувийг, мөнгөн хөрөнгө нийт активын 31.7 хувийг /25,066.8 сая төгрөг/ эзэлж байгаагаас үзэхэд нэг талаас, ББСБ-ууд зээлийн идэвхтэй үл ажиллагаа явуулахгүй байгаа буюу зээл олгох эх үүсвэр дутмаг байгааг, нөгөө талаас, ББСБ-уудын гаргаж буй санхүүгийн тайлан үнэн бодитоор гарч байгаад эргэлзэхэд хүргэж байна. Үүнийг бэлэн мөнгө буюу касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл /14,782.3 сая төгрөг/ нийт активын 18.7 хувийг эзэлж байгаагаас харж болно.**

## БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР